

COVID-19 вирусийн эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ



Empowered lives.
Resilient nations.

Нийгэм-эдийн засгийн нөлөөллийн үнэлгээний хамрах хүрээ

Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) нь COVID-19 цар тахлын нийгмийн орлого багатай, эмзэг бүлэгт үзүүлэх нөлөөг үнэлэх зорилгоор энэхүү судалгааг хийж байна. Энэхүү үнэлгээгээр МУ-ын Засгийн Газраас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, эмзэг бүлгийн эрсдэлийг даван туулах чадавхыг дэмжих, цар тахлын дараа эдийн засаг, нийгмийн салбаруудыг сэргээхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллийг бий болгоход зорьж байна.

Судалгааг эрсдэлд өртөх магадлалтай бүлгийн айл өрх, малчин өрх, жижиг-дунд бизнес эрхлэгчид, орон нутгийн удирдлагуудыг хамруулан хийж байна. Түүнчлэн цар тахлын үеийн сөрөг нөлөөлөлд хамгийн ихээр өртөх магадлалтай эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудыг голчлон анхаарсан болно.

Уг үнэлгээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, Сангийн яам, Үндэсний статистикийн хороо, Монгол Банк болон НҮБ-ын Хүүхдийн сан, Хүн амын сан, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага, Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний байгууллага зэрэг байгууллагууд хамтран ажиллаж байна.

Үнэлгээний үр дүнг хэрхэн ашиглах вэ?

Бодлого боловсруулагчид:

- COVID-19-ийн улмаас нийгэм, эдийн засагт учрах хор уршгийг бууруулах, нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн эрсдэлийг даван туулах чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Айл өрх болон нийгмийн тодорхой бүлгийн түвшинд сөрөг үр дагаврыг бууруулахад нийгмийг бүхэлд нь хамарсан хүртээмжтэй, цогц арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхэд суурь мэдээлэл бий болох юм.

Олон улсын хөгжлийн болон санхүүгийн байгууллагууд:

- COVID-19 цар тахлын үед авах хариу арга хэмжээ, хямралыг даван туулах санхүүжилтийн болон бусад хэрэгцээ шаардлагыг үнэлэх, үйл ажиллагааны уялдааг хангах, зохицуулалтыг дэмжих;
- Цар тахлын эсрэг хариу арга хэмжээ болон хямралыг даван туулах үйл ажиллагааг санхүүжүүлэх.

Судлаачид:

- Нийгэм, эдийн засгийн үнэлгээ нь цаашид энэ чиглэлээр хийгдэх судалгаанд нотолгоонд суурилсан мэдээллийн эх сурвалж болно.

Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагууд:

- Олон нийтэд нотолгоонд суурилсан мэдээлэл түгээх;
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, олон нийтийг хамарсан хэлэлцүүлэг зохион байгуулах суурь болно.

Нийгэм-эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ яагаад чухал вэ?

COVID-19 цар тахал нь Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд гарсан ахиц дэвшлийг ухраах, удаашруулах эрсдэлтэй байна. Шинэ коронавирусын халдвараас үүдсэн нийгэм, эдийн засгийн ноцтой хямрал бидэнд тулгарч байна. Тухайлбал, Азийн Хөгжлийн Банкны судалгаагаар цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хохирлын түвшингээрээ Монгол Улс нь Ази тивд 6 дугаарт эрэмбэлэгдэж байна. Монгол Улсын хувьд уул уурхай, худалдаа, үйлчилгээ, тээвэр, аялал жуулчлал, хөдөө аж ахуй зэрэг олон салбарт COVID-19 цар тахлын хор уршиг ихээр мэдрэгдэж байгаа боловч, нийгмийн эмзэг бүлгүүдэд үзүүлэх сөрөг нөлөө бүр ч их байгаа юм.

НҮБХХ-өөс хийж буй тус үнэлгээгээр уг цар тахал нь нийгмийн бүлэг, хүйсийн хувьд харилцан адилгүй нөлөөлж буйг харуулахаар зорьсон болно. Ингэснээр аливаа гамшгийн хор уршигт богино, дунд, урт хугацаанд олон талаар нэрвэгддэг бүлэг, ялангуяа эмэгтэйчүүдийн албан бус болон цалин хөлсгүй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн бусад сөрөг нөлөөг бодитоор үнэлж, бууруулахад чиглэсэн арга хэмжээг боловсруулах суурь болох юм.

Уг үнэлгээ нь эрсдэлд эмзэг бүлгүүдэд COVID-19 цар тахлаас үүдэлтэй үр дагаврыг тодорхойлж, цаашид тэдний амьжиргаанд учрах сөрөг нөлөөг урт хугацаанд тогтвортой бууруулах, эрсдэлийг даван туулах чадавхийг нэмэгдүүлэх илүү хүртээмжтэй, оновчтой, үр дүнтэй хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

НҮБХХ нь Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллагуудтай хамтран 'хэнийг ч орхигдуулахгүй байх' зарчмын дор COVID-19-ийн эрсдэлийг бууруулах, хямралыг даван туулах арга хэмжээнд нийгмийн эмзэг бүлгийн хэрэгцээ, шаардлагыг орхигдуулахгүй байхад анхааран ажиллаж байна.

